



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠨᠢᠶᠭᠦᠮ,
ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠦᠭᠢᠨ ᠪᠠᠶᠳᠠᠯ
(2017 ᠣᠨᠤ 7 ᠳᠤᠭᠠᠭᠠᠷ ᠰᠠᠷᠳ)



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2017 ОНЫ 7 ДУГААР САРД)


2017.08.14



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠤᠯᠤᠯ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд


Амаржсан эх, төрсөн хүүхэд жил бүрийн эхний 7 сарын байдлаар




Эндсэн хүүхэд, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Халдварт өвчний төрлөөр 2017 оны 7 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд 2017 оны 07 сарын байдлаар 669 эх амаржиж 674 хүүхэд мэнд төрлөө. Нялхсын эндэгдлийн 12 тохиолдол бүртгэгджээ. Цочмог халдварт өвчин 547 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 36.2 хувиар буурсан байна.




ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠢ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠡ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Ажилгүйдэл

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2017 оны 7 сарын эцэст



Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2017 оны эхний 7 сарын байдлаар




Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 7 дугаар сарын байдлаар 776 байгаагийн 56 хувь нь буюу 435 нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 269 нь дээд, 26 нь тусгай дунд, 70 нь техник мэргэжлийн, 324 нь бүрэн дунд, 54 нь суурь, 28 нь бага, 5 нь ямар ч боловсролгүй байна хүмүүс байна.




ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠤᠵᠠᠭᠤᠯᠡᠯᠲᠤ

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй


Төллөсөн хээлтэгч, жил бүрийн 7 сарын байдлаар




Гарсан төл, жилийн бүрийн 7 сарын байдлаар



Хорогдсон төл, жил бүрийн 7 сарын байдлаар




Бойжсон төл, жил бүрийн 7 сарын байдлаар



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй



Хорогдсон том мал, сумаар, 7 сарын байдлаар




7 сарын байдлаар аймгийн хэмжээнд 6090 толгой том мал зүй бусаар хорогдсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 дахин бага байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 154, үхэр 163, тэмээ 46, хонь 1878, ямаа 3849 байна. Нийт хорогдлын 30.8 хувийг хонь, 63.2 хувийг ямаа эзэлж байна.




ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠯᠤᠯᠤᠰ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠡᠢ ᠬᠡᠯᠲᠡᠰ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлвэрлэлт, борлуулалт /сая.төг/



Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, салбараар, 7 сарын байдлаар, хувиар




Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний 7 дугаар сард 6 тэрбум 713.9 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 3 хувиар өсчээ. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 56 хувийг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, 17 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 27 хувийг усан хангамжийн салбар тус тус эзэлж байна. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 80.5 хувийг буюу 5 тэрбум 402.5 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.




ᠮᠠᠯᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠤᠵᠢᠭᠦᠯᠡᠯᠲᠤ – ᠠᠵᠤ ᠶᠢᠯᠠᠳᠦᠢᠷ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв

Төсвийн орлогын бүтэц, мянган төгрөгөөр
2017 оны VII сард



Орон нутгийн зарлага санхүүжилт бүтцээр түүнд
эзлэх хувь



Төсвийн орлого Орон нутгийн төсөвт 30 тэрбум 127.9 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 99.9 хувиар, үүнээс татварын орлого 3 тэрбум 8.5 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 100.5 хувиар, татварын бус орлого 27 тэрбум 119.4 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 99.9 хувийн биелэлттэй байна.

Төсвийн зарлага Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн 85.1 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 96.1, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 93.3, бараа үйлчилгээний бусад зардлын 79.0, зардал санхүүжилтын их үүсвэр 96.6 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

ᠮᠠᠻᠤᠷ᠎ᠠ ᠡᠳᠢᠶ᠋ᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠶ᠋ᠵᠢᠭᠦᠯᠡᠯᠲᠤ – ᠲᠥᠰᠡᠪ

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2017-07</u>	<u>2017-07</u>	<u>2017-07</u>
		2016-07	2016-12	2016-06
Ерөнхий индекс	100	105.2	106.0	100.1
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	92.5	115.1	100.7
Согтууруулах ундаа, тамхи	3.2	104.0	102.8	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	107.9	106.2	100.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	109.9	96.3	98.7
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	110.9	107.9	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	101.4	101.4	100.0
Тээвэр	12.2	104.5	105.5	99.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.2	99.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	102.1	100.4	100.2
Боловсролын үйлчилгээ	4.7	142.7	108.9	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	107.2	104.4	104.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	101.8	101.0	100.0




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2017 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.1 хувь, өмнөх оны жилийн эцсээс 6.0, өмнөх оны мөн үеийнхээс 5.2 хувиар өсчээ.

Ерөнхий индекс 2017 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас 0.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус 0.7, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн индекс 1.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



**Хэрэглээний үнийн индекс
(өмнөх оны 12 сар=100)**






ᠮᠣᠩᠭᠦᠨ ᠵᠢᠷᠢᠮ ᠤᠨᠳᠦᠰᠢᠨ ᠤᠵᠦᠯᠡᠯᠦᠲᠤ

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст сая төг

Үзүүлэлт		
	2017-VI	2017-VII
Мөнгөний нийлүүлэлт M2	83786.2	79806.3
Сарын өөрчлөлт, хувиар	9.1	-4.8
Нийт хадгаламж	67572.1	67370.2
Сарын өөрчлөлт, хувиар	12.9	-0.3
Төгрөгийн хадгаламж	67056.8	66739.6
Сарын өөрчлөлт, хувиар	12.3	-0.5
Валютын хадгаламж	515.3	630.6
Сарын өөрчлөлт, хувиар	3 дахин	22.4

Чанаргүй зээл, сарын эцэст, сая төг




❖ Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2017 оны 7 дугаар сарын эцэст 79.8 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 4.0 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар буурчээ.

❖ Чанаргүй зээл 2017 оны 7 дугаар сарын эцэст 1.5 тэрбум төгрөг болж өмнөх сарынхаас 127.2 сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.7 хувийг эзэлж байна.



Харилцаа холбооны үйлчилгээний орлого мян.төг



Суурин телефон цэгийн тоо 704 холбоо ашиглалтын орлого 142.2 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 99.6 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний нэг цэгээр 16 суудалтай ажиллаж, интернетээр дунджаар 0.5 мянган хүнд үйлчилжээ.

ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ ᠬᠣᠯᠪᠤᠭ᠎ᠠ ᠰᠠᠯᠪᠠᠷᠢᠨ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠦᠵᠦᠭᠦᠯᠡᠯᠲ

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХААНААС, ХЭРХЭН АВАХ ВЭ ?

 Цахимаар:

www.1212.mn

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга авч байхыг хүсвэл ЭНД ДАРЖ бүртгүүлнэ үү

хэсэгт өөрийн e-mail хаягаар бүртгүүлснээр статистикийн мэдээллийг цаг алдалгүй тогтмол авч байх болно.

SOCIAL NETWORK



www.facebook.com/Статистик-Мэдээлэл



www.twitter.com/statistic_mn



Ухаалаг гар утас, таблет ашиглан статистик мэдээлэл авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг унших Монстат аппликейшн



Утсаар:



Лавлах утас
1900-1212



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠢ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Говь-Алтай аймаг, Засаг даргын
дэргэдэх Статистикийн хэлтэс

Утас : (7048-4278)

(7048-3442)

Э-майл : stat_altai@yahoo.com